

БАТЛАВ  
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН УУРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ *Жуу* Ж.УРАНЧИМЭГ

2022 оны *2* дугаар сарын *14* өдөр

## МОНГОЛЫН БҮХ АРД ТҮМНИЙ XV НААДМЫН НЭГДСЭН ЗААВАР

АЛТАЙ ХОТ  
2022 ОН

## АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ
2. НААДМЫН ХӨТӨЛБӨР
3. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
4. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ
5. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХУГАЦАА
6. ТАМИРЧДЫН ЭРХИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ
7. БҮРТГЭЛ, МЭДҮҮЛЭГ ӨГӨХ ЖУРАМ
8. САНХҮҮЖИЛТ
9. ДҮГНЭХ АРГАЧЛАЛ
10. СПОРТЫН ТӨРӨЛ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.1 хэсэг, Засгийн газрын 2021 оны 268 дугаар тогтоолыг үндэслэн Монголын бүх ард түмний спортын наадмыг зохион байгуулахад энэ зааврыг баримтална.

1.2. Монголын бүх ард түмний спортын наадмын /цаашид наадам гэх/ зорилго нь олон улсын стандартад нийцсэн, улсын хэмжээнд өргөн дэлгэр хөгжсөн спортын төрлүүдээр зохион байгуулах, дотоодын өрсөлдөөнийг дэмжих, тив дэлхийн тэмцээн наадамд өрсөлдөх тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

1.3. Монголын бүх ард түмний спортын наадамд дараах зарчмыг баримтална.

- **ШИЛДЭГ:** Улсын хэмжээнд зохион байгуулагдах наадмын оролцогчид нь спортын төрөл тус бүрээс шалгарсан тамирчид байна.
- **ХҮМҮҮНЛЭГ:** Тамирчдын тэгш боломж, жендерийн тэгш байдлыг хангана.
- **ХҮРТЭЭМЖТЭЙ:** Улсын хэмжээнд спортоор хичээллэгсэдийн бүх нийтийн оролцоог хангаж өндөр зэрэглэлийн тамирчдыг бэлтгэх, иргэн бүр оролцох боломжийг бүрдүүлнэ.
- **ШУДАРГА:** спортын ёс зүй, ил тод шүүлт, цэвэр шударга өрсөлдөөн, зохион байгуулалтын зарчмыг эрхэмлэнэ.
- **ТОГТВОРТОЙ:** Нийгэмд эерэг нөлөө үзүүлж, үндэсний бахархалыг нэмэгдүүлэх, иргэдийн насан туршдаа идэвхитэй хөдөлгөөнөөр хичээллэх урам зоригийг төрүүлнэ.

1.4 Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлүүд, тэмцээнд оролцогч байгууллага, баг, тамирчдад тавигдах шаардлага, тэмцээний удирдлага зохион байгуулалт, санхүүжилт, тайлан, дүгнэх арга аргачлалыг багтаасан болно.

### ХОЁР: НААДМЫН ХӨТӨЛБӨР

2.1. Монголын бүх ард түмний спортын наадам нь зуны олимпийн 14, өвлийн 2, паралимпийн 3, дифлимпын 2 нийт 21 төрлөөр зохион байгуулагдана.

### ГУРАВ: ТАВИГДАХ ШААРДЛАГА

#### 3.1. Байгууллагад тавигдах шаардлага

3.1 Наадамд оролцогч нь 18 сум, 2 тосгон, албан байгууллага аж ахуйн нэгжүүд байна. Спортын клубууд баг тамирчидаа тухай засаг захиргааны нэгжийн харьяалалын дагуу анхан шатны тэмцээнд оролцуулна.

#### 3.2 Тамирчинд тавигдах шаардлага

- Монгол улсын иргэн байна. Тухайн спортын холбооны олон улсын дүрэмд заасан насны ангиллаар оролцоно.

### ДӨРӨВ: СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ТАМИРЧДЫН ЭРХИЙН БАТАЛГААЖИЛТ

4.1. Наадамд оролцох баг тамирчдыг Тосгон, Сум, Албан байгууллагаасаа шалгарч аймгийн шигшээ тэмцээнд оролцож спортын /жин зай/ төрөл тус бүрд тэргүүн байранд шалгарсан /волейбол, сагсан бөмбөг, хөлбөмбөг/-ийн төрөлд баруун бүсээсээ 1-3-р байранд шалгарсан баг тамирчид 2022 оны 06 дугаар сарын 13-19-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдах “ШИГШЭЭ” тэмцээнд орох эрхээ баталгаажуулна.

## **ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХУГАЦАА**

5.1. Анхан шатны тэмцээнийг аймгийн Биеийн тамир, спортын газар, спортын салбар холбоодтой хамтран 2022 оны 02 дугаар сарын 25-27-н, 2022 оны 04 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд тус тус зохион байгуулна.

5.2. Наадмын /волейбол, сагсан бөмбөг 5x5, хөлбөмбөг/-ийн төрлийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг тухайн товлогдсон аймагт 2022 оны 05 дугаар сарын 11-20-ны өдрүүдэд зохион байгуулна.

## **ЗУРГАА. БҮРТГЭЛ МЭДҮҮЛЭГ ӨГӨХ ЖУРАМ**

6.1. Анхан шатны тэмцээнд оролцох баг тамирчдыг мэлүүлгийг “ХАВСРАЛТ МАЯГТЫН” дагуу бөглөж 2022 оны 02 дугаар сарын 24-ний дотор [govi-altai.sport.gov.mn](http://govi-altai.sport.gov.mn) хаягаар ирүүлж тэмцээнд оролцох эртэй болно.

**ЖИЧ:** Заасан хугацаанд мэдүүлэг өгөөгүй баг тамирчид анхан шатны тэмцээнд оролцох боломжгүйг анхаарна уу.

## **НАЙМ: САНХҮҮЖИЛТ**

8.1. Спортын наадмын төрлүүдийн анхан шатны тэмцээнд оролцоход шаардагдах зардлыг тухайн тэмцээнд оролцуулж буй байгууллага бүрэн хариуцана.

- Спортын наадмын бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох /волейбол, сагсан бөмбөг, хөлбөмбөг/-ийн төрлийн зардлыг аймгийн ЗДТГ, БТСГ, тухайн спортын салбар холбоод хариуцана.

•

## **ЕС. ДҮГНЭХ АРГАЧЛАЛ**

9.1. Наадамд оролцогч байгууллагыг Олон улсын спортын наадмын дүгнэх аргачлалын дагуу медалийн чанараар дүгнэж байр эзлүүлнэ.

**АРАВ. СПОРТЫН ТӨРӨЛ**

№	СПОРТЫН ТӨРӨЛ	ХУГАЦАА	ЖИН ЗАЙ	НАСНЫ ХЯЗГААР
1	Пауэрлифтинг	II/25-27	<b>Эрэгтэй:</b> -66кг, -74кг, -83кг, -93кг, -105кг, -120кг, +120кг. <b>Эмэгтэй:</b> -57кг, +57кг, -63кг, +63кг.	18 түүнээс дээш нас
2	Шатар	II/25-27	Эрэгтэй -1, эмэгтэй -1	18 түүнээс дээш нас
3	Жүдо бөх /өсвөр үе/	II/25-27	Өсвөр үеийн 2022 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээний заавраар	
4	Сагсан бөмбөг /5х5/	II/25-27	<b>Эрэгтэй:</b> -10, <b>эмэгтэй:</b> -10,	18 түүнээс дээш нас
5	Сагсан бөмбөг /3х3/	II/25-27	<b>Эрэгтэй:</b> -4, <b>эмэгтэй:</b> -4,	18 түүнээс дээш нас
6	Чөлөөт бөх	II/25-27	<b>Эрэгтэй:</b> 57кг, 65кг, 74кг, 86кг,97кг, 125кг. <b>Эмэгтэй:</b> 50кг, 53кг, 57кг, 62кг, 68кг, -76кг,	18 түүнээс дээш нас
7	Таеквондо	II/25-27	<b>Эрэгтэй:</b> 58кг, -63кг, -68кг, 74кг,-80кг, +80кг. <b>Эмэгтэй:</b> 46кг, -49кг, +53кг, 57кг, -62кг,+62кг	18 түүнээс дээш нас
8	Волейбол	IV/22-24	<b>Эрэгтэй:</b> -12, <b>эмэгтэй:</b> -12,	18 түүнээс дээш нас
9	Даам	IV/22-24	<b>Эрэгтэй:</b> -1, <b>эмэгтэй:</b> -1,	18 түүнээс дээш нас
10	Самбо бөх	IV/22-24	<b>Эрэгтэй:</b> 58кг, -64кг, -71кг, 79кг,-88кг, -98кг, +198кг. <b>Эмэгтэй:</b> 50кг, -54кг, +59кг, 65кг, +72кг, -80кг, +80кг.	18 түүнээс дээш нас
11	Дугуй	IV/22-24	<b>Эрэгтэй:</b> -1 ганцаарчилсан кросс коаунтри 30 км, <b>эмэгтэй:</b> - ганцаарчилсан кросс коаунтри 21 км. <b>Баг:</b> эрэгтэй 4 хүнтэй засмал замын 50 км.	18 түүнээс дээш нас
12	Ширээний теннис	IV/23-24	<b>Эрэгтэй:</b> -1, <b>эмэгтэй:</b> -1,	18 түүнээс дээш нас
13	Хөлбөмбөг	IV/23-24	<b>Эрэгтэй:</b> 15	16 түүнээс дээш нас
14	Хөнгөн атлетик	IV/23-24	<b>Эрэгтэй:</b> 100м, 200м, 400м, 800м,1500м, 5000м, 10000м, уртын харайлт, гурвын харайлт, бөөрөнцөг түлхэлт, зээрэнцэг шидэлт. <b>Эмэгтэй:</b> 100м, 200м, 400м, 800м,1500м, 5000м, 10000м, уртын харайлт, гурвын харайлт, бөөрөнцөг түлхэлт, зээрэнцэг шидэлт. <b>Буухиа</b> – 4х100м, 4х400м	17 түүнээс дээш нас

Наадам зохион байгуулах ажлын хэсэг  
Утас: 99223033, 99231857